



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал 2018/2

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2018/2



sukhbaatar.nso.mn

www.1212.mn



Monstat



ezStat

Статистикийн хэрэглэгч та бүхэн манай хэвлэмэл бүтээгдэхүүн болон тоо мэдээллүүдийг MONSTAT, ezStat аппликейшнуудээр дамжуулан Apple-ын iPhone, iPad төхөөрөмжтэй бол App store-с, андройд үйлдлийн системийн төхөөрөмжтэй бол Google play-с татан авч, суулгаж ашиглах боломжтой.

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХААНААС, ХЭРХЭН АВАХ ВЭ ?

 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан

www.sukhbaatar.nso.mn

Сүхбаатар аймгийн статистик
хэлтсийн вэб хуудас



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах ezStat аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
МонСтат аппликейшн




Download on the
App Store

 **Google play**



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү 

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)

СҮХБААТАР АЙМАГ



[www.facebook.com/
statistic](http://www.facebook.com/statistic)



Утсаар:



Лавлах утас

1900-1212

Сүхбаатар аймаг

7051-8203



СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

**2 сар
2018**

Баруун-Урт сум



ГАРЧИГ

| | |
|---|-------|
| Ерөнхий тэмдэглэл | 3 |
| Аргачлалын тайлбар..... | 4-5 |
| Товч танилцуулга | 6-11 |
| Үндсэн үзүүлэлтүүд..... | 12 |
| I. Нийгмийн үзүүлэлт | |
| I.2 Хөдөлмөр..... | 13-15 |
| I.3 Нийгмийн даатгал, нийгмийн халамж | 16 |
| I.4 Эрүүл мэнд..... | 17-18 |
| I.5 Гэмт хэрэг..... | 19-20 |
| II. Эдийн засгийн үзүүлэлт | |
| II.1 Мөнгө, банк..... | 21 |
| II.2 Төрийн санхүү..... | 22-23 |
| II.3 Үнэ..... | 24-25 |
| II.4 Хөдөө аж ахуй | 26-27 |
| II.5 Аж үйлдвэр | 28-30 |



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэлгээ:

Сумдын нэр:

| | |
|---------------|-----------------|
| АС Асгат | ТШ Түвшинширээ |
| БД Баяндэлгэр | ТЦ Түмэнцогт |
| ДА Дарьганга | УБ Уулбаян |
| МХ Мөнххаан | ХА Халзан |
| НА Наран | ЭЦ Эрдэнэцагаан |
| ОН Онгон | БУ Баруун-Урт |
| СҮ Сүхбаатар | |

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-VII, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

| | | |
|----------------------|------|------------------|
| ... Мэдээлэл байхгүй | x | Бүтцийн өөрчлөлт |
| 0.0 Маш бага тоо | +, - | Зөрүү |
| - Гүйцэтгэл байхгүй | * | Дахин |

□ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 18-17 нь 2018 оны үзүүлэлтийн тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл.

VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-нээс шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл, ангилал нь урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.
 - Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг аргазүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.



- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газар нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2018 оны эхний 2 сарын байдлаар)


I. Нийгмийн үзүүлэлт



I.1 Хүн ам

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээгээр 2 дугаар сард 182 хүүхэд шинээр мэндэлж, 55 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 127 болж урьд оны мөн үеэс 0.8 хувь буюу 1 хүнээр буурлаа. 1000 хүнд ногдох төрөлт 3.0, нас баралт 0.4 пункттэй байна.

Зураг.I.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо




I.2 Хөдөлмөр

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2018 оны 2 дугаар сарын эцэст 1322 болсны 674 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 993 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.1 хувь буюу 48 хүнээр, 2017 оны 12 дугаар сарын эцсээс 12.1 хувь буюу 107 хүнээр тус тус өссөн байна.

Эхний 2 сарын байдлаар хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт 558 ажилгүй иргэн шинээр бүртгүүлснээс 40 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг.I.2 Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд





Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 57.4 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.4 хувь нь магистр, доктор, 23.4 хувь нь бакалавр, 2.8 хувь нь тусгай дунд, 9.8 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 42.5 хувь нь бүрэн дунд, 13.1 хувь нь суурь, 6.4 хувь нь бага боловсролтой, 1.5 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Зураг.1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр, эхний 2 сарын байдлаар



Эхний 2 сарын байдлаар 40 шинэ ажлын байр бий болсны өмнөх оны мөн үеэс 4 дахин буюу 30-аар өсчээ.



1.3 Нийгмийн даатгал, халамж:

Нийгмийн халамжийн сангаас 0.6 тэрбум төгрөгийг 9.6 мянган иргэнд, улсын төсвөөс 1.1 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 9.7 мянган иргэнд тус тус олгосон байна.



1.4 Эрүүл мэнд


Аймгийн хэмжээнд эхний 2 сарын байдлаар 37.0 мянган хүнд үзлэг хийсэн нь 16.9 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгт 7.7 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 30.0 хувиар тус тус буурч, 2.3 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 3.3 мянган удаа гарсны 0.8 мянга буюу 24.2 хувь нь алсын дуудлага байлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал алсын дуудлага 11.1 хувиар буурсан байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны эхний 2 сард амаржсан эх 181, амьд төрсөн хүүхдийн тоо 182 болжээ. Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 7 буюу 4.0 хувь, хүүхдийн тоо 10 буюу 5.8 хувиар тус тус өссөн байна.



Зураг.1.4 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо эхний 2 сард 143 болж, өмнөх оны мөн үеийнхээс 120 хүн буюу 45.6 хувиар буурчээ.




I.4 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2018 оны эхний 2 сард 50 гэмт хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 2 хүн нас барж, 23 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 11-ээр буурчээ. Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 138.1 сая төгрөгийн хохирол учирсны 34.8 хувь буюу 48.1 сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 27 хүн холбогдон сэжиглэгдсэний 44.5 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 90 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеийн адил түвшинд байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 16 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 44.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 37.7 пунктээр буурчээ.

Зураг.1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо





II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, банк:

Монгол банкны мэдээгээр ХААН, Төрийн, Хас, Голомт, Капитал банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 119.4 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 4.3 тэрбум төгрөг буюу 1.0 хувиар, өмнөх оны мөн үеэс 14.8 тэрбум төгрөг буюу 14.2 хувиар тус тус өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 55.9 тэрбум төгрөг болж оны эхнээс 0.8 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 14.5 тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг.II.1. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, тэрбум.төг



Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээл 2 дугаар сарын эцэст 3.2 тэрбум болж оны эхнээс 0.4 тэрбум төгрөгөөр буурч, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.7 хувийг эзэлж байна.




II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого эхний 2 сард 7.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.2 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар өсч, төсвийн зарлага санхүүжилт 7.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.6 тэрбум төгрөг буюу 9.1 хувиар өсчээ.

Аймгийн нэгдсэн төсвийн 9.1 хувийг татварын орлого, 2.9 хувийг татварын бус орлого, 88.0 хувийг тусламжийн орлого тус тус эзэлж байна.


Зураг.II.2 Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг



**II.3 Хэрэглээний үнийн индекс**

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2018 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 6.3 хувь, жилийн эцсээс 1.8 хувь, өмнөх сараас 0.5 хувиар тус тус өслөө.

Зураг.II.3 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)

**Хүснэгт.II.1 Хэрэглээний үнийн индекс, бүлгээр**

| Бараа үйлчилгээний бүлэг | $\frac{2018.II}{2017.II}$ | $\frac{2018.II}{2017.XII}$ | $\frac{2018.II}{2018.I}$ |
|---|---------------------------|----------------------------|--------------------------|
| Ерөнхий индекс | 106.3 | 101.8 | 100.5 |
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 107.2 | 104.0 | 100.4 |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 105.8 | 101.9 | 100.8 |
| Хувцас, бөс бараа, гутал | 104.9 | 101.6 | 100.0 |
| Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш | 99.0 | 100.0 | 100.0 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 104.6 | 101.1 | 100.3 |
| Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ | 114.0 | 101.7 | 100.0 |
| Тээвэр | 113.4 | 101.9 | 101.9 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 99.5 | 100.0 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ | 107.8 | 100.0 | 100.0 |
| Боловсролын үйлчилгээ | 99.5 | 100.0 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 100.0 | 100.0 | 100.0 |
| Бусад бараа, үйлчилгээ | 101.9 | 100.7 | 100.0 |



Ерөнхий индекс жилийн эцсээс 1.8 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 4.0 хувиар, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 1.9 хувиар, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.6 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 1.1 хувиар, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.7 хувиар, тээврийн бүлгийн үнэ 1.9 хувиар, бусад бараа, үйлчилгээний үнэ 0.7 хувиар өссөн нь тус тус голлон нөлөөлжээ.



II.4 ХӨДӨӨ АЖ АХУЙ

Малын онд оролт: Том малын зүй бус хорогдол 2018 оны эхний 2 дугаар сарын байдлаар 17.6 мянган толгой болж, өмнөх оны мөн үеэс 11.9 мянган толгой буюу 3.1 дахин өссөн байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 3, адуу 751, үхэр 1.5 мянга, хонь 6.8 мянга, ямаа 8.5 мянган толгой байна. Нийт хорогдсон малын 38.8 хувийг хонь, 48.3 хувийг ямаа эзэлж байна. Аймгийн хэмжээнд өвчнөөр хорогдсон мал 2018 оны эхний 2 дугаар сард 90 толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.4 мянган толгой буюу 97.4 хувиар буурсан байна.



II.5 АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 8.0 тэрбум төгрөг болж өмнөх оноос 0.9 тэрбум төгрөг буюу 12.6 хувиар өсчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: уул уурхай, олборлох аж үйлдвэрийнх 7.1 тэрбум төгрөг болж 13.6 хувь, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 0.8 тэрбум төгрөг буюу 0.1 хувиар, боловсруулах аж үйлдвэрийнх 44.8 сая төгрөг буюу 45 хувиар тус тус өслөө.

Оны үнээр 47.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 12.8 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал, цайрын баяжмал, дулаан, цахилгаан, бууз, банш, бялуу, нарийн боов, талх, хэвийн боов, хэрчсэн гурил, ажлын хувцас, пальто, өмд, гал тогооны өрөөний модон тавилга, гэрийн бусад модон тавилга зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс өссөн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН

ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 1 сарын байдлаар

| | Хэмжих нэгж | 2016 | 2017 | 2018 | Зөрүү | $\frac{2018}{2017}$ % |
|---|-------------|----------|-----------|-----------|----------|-----------------------|
| Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд | | | | | | |
| Төрсөн хүүхэд | хүн | 210 | 172 | 182 | 10 | 105.8 |
| Нялхасын эндэгдэл | хүн | 6 | 4 | 1 | - 3 | 25.0 |
| Бүртгэлтэй ажилгүй иргэд | хүн | 958 | 945 | 993 | 48 | 105.1 |
| Халдварт өвчнөөр өвчлөгчид | хүн | 163 | 263 | 143 | - 120 | 54.4 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | тоо | 34 | 61 | 50 | - 11 | 82.0 |
| Хэрэгт холбогсод | хүн | 22 | 65 | 27 | - 38 | 41.5 |
| Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт | | | | | | |
| Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар | хувь | 100.3 | 101.2 | 101.8 | 0.6 | 100.6 |
| Иргэдийн хадгаламж | сая.төг | 31 631.3 | 41 345.5 | 55 889.1 | 14 543.6 | 135.2 |
| Зээлийн өрийн үлдэгдэл | сая.төг | 92 993.8 | 104 511.9 | 119 360.4 | 14 848.5 | 114.2 |
| Орон нутгийн төсвийн орлого | сая.төг | 7 529.5 | 7 322.0 | 7 531.9 | 209.9 | 102.9 |
| Орон нутгийн төсвийн зарлага | сая.төг | 6 564.3 | 6 956.8 | 6 546.5 | - 410.3 | 94.1 |
| Том малын зүй бусын хорогдол | | | | | | |
| - Тэмээ | тол | 11 | 2 | 3 | 1.0 | 150.0 |
| - Адуу | тол | 3 324 | 41 | 751 | 710 | 18.3* |
| - Үхэр | тол | 5 841 | 2 402 | 1 521 | - 881 | 63.3 |
| - Хонь | тол | 20 843 | 2 165 | 6 828 | 4 663 | 3.2* |
| - Ямаа | тол | 39 497 | 1 072 | 8 487 | 7 415 | 7.9* |
| Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн | сая.төг | 6 143.2 | 7 139.7 | 8 039.1 | 899.4 | 112.6 |
| - Борлуулсан бүтээгдэхүүн | сая.төг | 12 081.1 | 34 222.9 | 46 998.0 | 12 775.1 | 137.3 |

**I.2 ХӨДӨЛМӨР****I.2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар**

| Сум | 2016 | | 2017 | | 2018 | 2018.II 2017.II % |
|--------------|------|-----|------|-----|------|----------------------|
| | II | XII | II | XII | II | |
| Асгат | 20 | 27 | 13 | 14 | 15 | 115.4 |
| Баяндэлгэр | 22 | 31 | 27 | 47 | 51 | 188.9 |
| Дарьганга | 16 | 36 | 37 | 27 | 34 | 91.9 |
| Мөнххаан | 15 | 17 | 56 | 49 | 71 | 126.8 |
| Наран | 8 | 14 | 24 | 16 | 55 | 2.3* |
| Онгон | 26 | 25 | 25 | 40 | 63 | 2.5* |
| Сүхбаатар | 29 | 21 | 26 | 56 | 56 | 2.1* |
| Түвшинширээ | 43 | 31 | 38 | 49 | 46 | 121.1 |
| Түмэнцогт | 28 | 50 | 55 | 59 | 41 | 74.5 |
| Уулбаян | 13 | 9 | 28 | 65 | 63 | 2.3* |
| Халзан | 14 | 15 | 17 | 15 | 31 | 182.4 |
| Эрдэнэцагаан | 32 | 42 | 17 | 178 | 156 | 9.2* |
| Баруун-Урт | 692 | 443 | 582 | 271 | 311 | 53.4 |
| Дүн | 958 | 761 | 945 | 886 | 993 | 105.1 |

I.2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

| Сум | Бүгд | эмэгтэй | Боловсролын түвшингээр | | | | | | | | Насны бүлгээр | | | | | |
|--------------|------|---------|------------------------|------|-----------------------------|--|------------|-------|------|--------------|---------------|-------|-------|-------|-------|-----|
| | | | Магистр, доктор | Дээд | Тусгай мэргэж- лийн дунд | Техник болон мэр- гэжлийн анхан шалтны | Бүрэн дунд | Суурь | Бага | Боловсролгүй | 15-24 | 25-34 | 35-44 | 45-54 | 55-59 | 60+ |
| | | | | | | | | | | | | | | | | |
| Асгат | 15 | 8 | - | 4 | - | - | 8 | 2 | 1 | - | 7 | 4 | 1 | 3 | - | - |
| Баяндэлгэр | 51 | 28 | - | 6 | 1 | 7 | 21 | 11 | 3 | 2 | 10 | 20 | 13 | 8 | - | - |
| Дарьганга | 34 | 17 | - | 5 | - | 8 | 8 | 13 | - | - | 9 | 12 | 9 | 4 | - | - |
| Мөнххаан | 71 | 29 | - | 16 | 4 | 1 | 39 | 2 | 7 | 2 | 11 | 25 | 22 | 12 | 1 | - |
| Наран | 55 | 28 | - | 13 | 2 | 3 | 16 | 16 | 1 | 4 | 16 | 10 | 16 | 10 | 2 | 1 |
| Онгон | 63 | 28 | - | 10 | - | 5 | 31 | 13 | 4 | - | 11 | 19 | 26 | 6 | 1 | - |
| Сүхбаатар | 56 | 27 | - | 14 | - | 4 | 30 | 5 | 1 | 2 | 17 | 21 | 7 | 10 | - | 1 |
| Түвшинширээ | 46 | 22 | - | 10 | 2 | 5 | 15 | 9 | 5 | - | 13 | 14 | 14 | 4 | 1 | - |
| Түмэнцогт | 41 | 22 | - | 4 | 4 | 4 | 21 | 4 | 3 | 1 | 8 | 5 | 17 | 11 | - | - |
| Уулбаян | 63 | 35 | - | 7 | 2 | 6 | 26 | 10 | 11 | 1 | 8 | 30 | 12 | 10 | - | 3 |
| Халзан | 31 | 16 | - | - | 1 | - | 26 | 3 | 1 | - | 8 | 7 | 6 | 9 | 1 | - |
| Эрдэнэцагаан | 156 | 82 | - | 17 | 3 | 16 | 77 | 31 | 9 | 3 | 23 | 65 | 46 | 17 | 4 | 1 |
| Баруун-Урт | 311 | 161 | 4 | 106 | 10 | 39 | 118 | 21 | 10 | 3 | 58 | 139 | 65 | 38 | 10 | 1 |
| Дүн | 993 | 503 | 4 | 212 | 29 | 98 | 436 | 140 | 56 | 18 | 199 | 371 | 254 | 142 | 20 | 7 |



I.2.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

| Сум | 2016 | | 2017 | | 2018 | <u>2018.I-II</u> 2017.I-II % |
|--------------|------------|--------------|------------|--------------|------------|---------------------------------|
| | I-II | I-XII | I-II | I-XII | I-II | |
| Асгат | 19 | 117 | 41 | 192 | 22 | 53.7 |
| Баяндэлгэр | 24 | 195 | 29 | 152 | 12 | 41.4 |
| Дарьганга | 31 | 143 | 11 | 63 | 21 | 190.9 |
| Мөнххаан | 12 | 52 | 50 | 165 | 39 | 78.0 |
| Наран | 8 | 94 | 32 | 211 | 46 | 143.8 |
| Онгон | 18 | 116 | 2 | 157 | 51 | 25.5* |
| Сүхбаатар | 31 | 140 | 18 | 237 | 4 | 22.2 |
| Түвшинширээ | 25 | 116 | 29 | 224 | 17 | 58.6 |
| Түмэнцогт | 25 | 110 | 10 | 128 | 32 | 3.2* |
| Уулбаян | 13 | 88 | 28 | 177 | 12 | 42.9 |
| Халзан | 13 | 79 | 18 | 93 | 32 | 177.8 |
| Эрдэнэцагаан | 66 | 286 | 11 | 308 | 6 | 54.5 |
| Баруун-Урт | 627 | 2 268 | 306 | 2 050 | 264 | 86.3 |
| Дүн | 912 | 3 804 | 585 | 4 157 | 558 | 95.4 |

I.2.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

| Сум | 2016 | | 2017 | | 2018 | <u>2018.I-II</u> 2017.I-II % |
|--------------|-----------|------------|------------|--------------|-----------|---------------------------------|
| | I-II | I-XII | I-II | I-XII | I-II | |
| Асгат | - | 32 | 32 | 114 | - | - |
| Баяндэлгэр | 2 | 96 | 11 | 68 | - | - |
| Дарьганга | 5 | 29 | 4 | 21 | 1 | 25.0 |
| Мөнххаан | - | 8 | - | 43 | - | - |
| Наран | - | 46 | 14 | 106 | 2 | 14.3 |
| Онгон | - | 6 | - | 43 | - | - |
| Сүхбаатар | - | 44 | 3 | 83 | - | - |
| Түвшинширээ | 1 | 19 | - | 87 | 9 | - |
| Түмэнцогт | 1 | 11 | - | 12 | 5 | - |
| Уулбаян | - | 42 | - | 19 | 1 | - |
| Халзан | - | 33 | 9 | 42 | 2 | 22.2 |
| Эрдэнэцагаан | 6 | 86 | 2 | 26 | 4 | 2.0* |
| Баруун-Урт | 26 | 298 | 46 | 460 | 16 | 34.8 |
| Дүн | 41 | 750 | 121 | 1 124 | 40 | 33.1 |



I.2.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

| Сум | Шинэ ажлын байранд орсон хүний тоо | | Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар | | | |
|-------------|------------------------------------|-----------|--|---|---|-----------------------------------|
| | | | Боловсруулах үйлдвэр | Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал | Үйлчилгээн ий бусад үйл ажиллагаа |
| | 2017 I-II | 2018 I-II | | | | |
| Наран | 2 | - | - | - | - | - |
| Түвшинширээ | - | 1 | - | - | 1 | - |
| Уулбаян | - | 1 | - | - | 1 | - |
| Халзан | 5 | - | - | - | - | - |
| Баруун-Урт | 3 | 38 | 20 | 1 | - | 17 |
| Дүн | 10 | 40 | 20 | 1 | 2 | 17 |



I.3. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

| Үзүүлэлт | | 2018.I- II | |
|---|---|---------------|----------------|
| | | Хүн тоо | сая.төг |
| Халамжийн сан | 1 Халамжийн тэтгэвэр | 1 070 | 301.5 |
| | 2 Халамжийн тэтгэмж | 481 | 50.8 |
| | Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд 1 удаа | 436 | 28.2 |
| | өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн зардал | 36 | 8.6 |
| | 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн | 2 | 2.4 |
| | Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа | 3 | 3.6 |
| | 2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж | 4 | 8.0 |
| | 3 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж | 943 | 135.7 |
| | байнгын асаргаа шаардлагатай Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж | 430 | 52.7 |
| | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж | 190 | 23.6 |
| | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж | 137 | 16.7 |
| | Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж | 16 | 1.9 |
| | Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж | 9 | 1.5 |
| Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах | 21 | 2.2 | |
| 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж | 140 | 37.1 | |
| 4 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ | 1 | 0.2 | |
| 5 Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу | 86 | 17.0 | |
| 6 ХБ-тэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж | 236 | 29.4 | |
| 7 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал | 6 806 | 93.9 | |
| Улсын төсвөөс | 1 Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж | 658 | 44.5 |
| | 2 Алдар эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж | 4 238 | 585.1 |
| | 3 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж | 12 | 3.6 |
| | 4 Насны хишиг | 2 149 | 180.8 |
| | 5 Цалинтай ээж хөтөлбөр | 2 698 | 238.5 |
| ДҮН | | 19 378 | 1 681.0 |

**I.3 ЭРҮҮЛ МЭНД****I.3.1 ЭРҮҮЛ МЭНД**

| | Хэмжих нэгж | 2017.I-II | 2018.I-II | Өсөлт | |
|-------------------------------------|-------------|-----------|-----------|-------|-------|
| | | | | тоо | хувь |
| 1. Нийт үзлэг | мян.хүн | 44.5 | 37.0 | -7.5 | 83.1 |
| 2. Ор хоног | мян.хүн | 17.8 | 17.9 | 0.1 | 100.6 |
| 3. Урьдчилан сэргийлэх үзлэг | мян.хүн | 11 | 7.7 | -3.3 | 70.0 |
| 4. Эмчлүүлсэн хүний тоо | мян.хүн | 2.2 | 2.3 | 0.1 | 104.5 |
| 5. Түргэн тусламжын дуудлага | мян.хүн | 3.1 | 3.3 | 0.2 | 106.5 |
| Үүнээс: алсын дуудлага | мян.хүн | 0.9 | 0.8 | -0.1 | 88.9 |
| 6. Осол гэмтлийн дуудлага | хүн | 104 | 95 | -9 | 91.3 |
| 7. Нийт нас баралт | хүн | 44 | 55 | 11 | 125.0 |
| 8. Амаржсан эх | хүн | 174 | 181 | 7 | 104.0 |
| Үүнээс: амьд төрсөн хүүхэд | хүн | 172 | 182 | 10 | 105.8 |
| 9. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд | хүн | 4 | 1 | -3 | 25.0 |
| 10. 1-5 хүртлэх насны эндсэн хүүхэд | хүн | - | - | - | - |

I.3.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

| Сум | Амаржсан эх | Амьд төрсөн хүүхэд | 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд |
|--------------|-------------|--------------------|---------------------------------|--------------------------------|
| Асгат | - | - | - | - |
| Баяндэлгэр | 1 | - | - | - |
| Дарьганга | - | - | 1 | - |
| Мөнххаан | 1 | 1 | - | - |
| Наран | - | - | - | - |
| Онгон | - | - | - | - |
| Сүхбаатар | 1 | 1 | - | - |
| Түвшинширээ | 1 | 1 | - | - |
| Түмэнцогт | 1 | 1 | - | - |
| Уулбаян | - | - | - | - |
| Халзан | - | - | - | - |
| Эрдэнэцагаан | 11 | 11 | - | - |
| Баруун-Урт | 165 | 167 | - | - |
| Дүн | 181 | 182 | 1 | - |



I.3.3 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, сумаар

| Халдварт өвчин | Хэмжих нэгж | 2017.I-II | 2018.I-II | Өсөлт | |
|--------------------|-------------|-----------|-----------|-------|------|
| | | | | Тоо | Хувь |
| Вируст гепатит | хүн | 1 | - | - | - |
| Гар хөл амны өвчин | хүн | 80 | 18 | -62 | 22.5 |
| Бруцеллэз | хүн | 4 | - | - | - |
| Салхинцэцэг | хүн | 73 | 66 | -7 | 90.4 |
| Сүрьеэ | хүн | 12 | 7 | -5 | 58.3 |
| Тэмбүү | хүн | 32 | 23 | -9 | 71.9 |
| Заг | хүн | 30 | 18 | -12 | 60.0 |
| Трихоминиаз | хүн | 20 | 10 | -10 | 50.0 |
| Бусад | хүн | 11 | 1 | -10 | 9.1 |
| Бүгд | хүн | 263 | 143 | -120 | 54.4 |

I.3.4 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

| Сум | Халдвар өвчнөөр өвчлөгчид бүгд | | | Вируст гепатит | Гар хөл амны өвчин | Бруцеллэз | Салхинцэцэг | Сүрьеэ | Тэмбүү | Заг | Трихоминиаз |
|--------------|--------------------------------|-----------|-----------------|----------------|--------------------|-----------|-------------|--------|--------|-----|-------------|
| | 2017.I-II | 2018.I-II | 1000 хүн тутамд | | | | | | | | |
| Асгат | 1 | 2 | 1.1 | - | - | - | - | 1 | 1 | - | - |
| Баяндэлгэр | 4 | 2 | 0.4 | - | - | - | 1 | 1 | - | - | - |
| Дарьганга | 2 | 2 | 0.7 | - | - | - | - | - | 1 | 1 | - |
| Мөнххаан | - | 2 | 0.4 | - | - | - | - | 1 | - | - | 1 |
| Наран | 7 | 5 | 3.1 | - | - | - | 1 | - | 1 | 3 | - |
| Онгон | 9 | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Сүхбаатар | 9 | 3 | 0.9 | - | - | - | - | - | 1 | 2 | - |
| Түвшинширээ | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Түмэнцогт | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Уулбаян | 5 | 4 | 1.4 | - | - | - | 1 | - | 1 | 1 | 1 |
| Халзан | 1 | 2 | 1.2 | - | - | - | 1 | 1 | - | - | - |
| Эрдэнэцагаан | 3 | 3 | 0.4 | - | - | - | - | 1 | 1 | - | 1 |
| Баруун-Урт | 220 | 118 | 5.6 | - | 18 | - | 62 | 2 | 17 | 11 | 7 |
| Дүн | 263 | 143 | 2.3 | - | 18 | - | 66 | 7 | 23 | 18 | 10 |

**I.4 ГЭМТ ХЭРЭГ****I.4.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, төрлөөр**

| Хэргийн төрөл | 2017.I-II | 2018.I-II |
|--|-----------|-----------|
| Бүртгэгдсэн хэрэг-бүгд | 61 | 50 |
| Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг | 1 | 3 |
| Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын гэмт хэрэг | 27 | 21 |
| Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 2 | 2 |
| Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | 22 | 21 |
| Бусдын эд хөрөнгийг хулгайлах | 20 | 14 |
| Үүнээс: Хувийн өмчийг хулгайлах | 10 | 5 |
| Малын хулгай | 10 | 9 |
| Олон нийтийн аюулгүй байдлын ашиг сонирхолын эсрэг гэмт хэрэг | 2 | - |
| Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 7 | 3 |
| Бусад гэмт хэрэг | - | - |
| Гэмт хэргийн улмаас учирсан хохирол | | |
| Гэмтэж осолдсон хүн | 32 | 23 |
| Нас барсан хүн | 5 | 2 |
| Нийт хохирол /сая төгрөг/ | 102.9 | 138.1 |
| Нөхөн төлүүлсэн хохирол /хувь/ | 71.7 | 34.8 |

I.4.2 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, сумаар

| Сум | 2016.I-II | 2017.I-II | 2018.I-II |
|--------------|-----------|-----------|-----------|
| Асгат | - | 1 | 1 |
| Баяндэлгэр | 1 | 3 | - |
| Дарьганга | 2 | 3 | 2 |
| Мөнххаан | 4 | 9 | 3 |
| Наран | - | - | 1 |
| Онгон | 1 | 2 | 1 |
| Сүхбаатар | 1 | 2 | 4 |
| Түвшинширээ | 2 | 3 | 2 |
| Түмэнцогт | 3 | 1 | 6 |
| Уулбаян | 1 | 5 | 5 |
| Халзан | - | 3 | 3 |
| Эрдэнэцагаан | 2 | 8 | 3 |
| Баруун-Урт | 17 | 21 | 19 |
| Дүн | 34 | 61 | 50 |



I.4.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО

| Сэжигтэн, яллагдагчийн тоо | 2016.I-II | 2017.I-II | 2018.I-II |
|----------------------------|-----------|-----------|-----------|
